

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бичиг

Боть XLIII

Улаанбаатар

2019

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-НЫ ХЭЛ ДЭХ АСУУХ СУЛ ҮГИЙГ ШИНЖЛЭХ НЬ¹

Инь Хуа

Агуулгын товч: Тус өгүүлэлд дундад эртний монгол хэлний асуух сул үгийн тухай онгөрсний судалганд суурилж, цуваа цагийн хэл шинжлэлийн үүднээс гардаж “Монголын нууц товчоо”-ны хэлэн дэх асуух сул үгийн хэрэглэгдсэн байдал, хэрэглэгдсэн онцлогийг орчин цагийн монгол хэлний сул үгтэй хооронд нь харьцуулахаар дамжин, зөрүүтэй талыг нь илүүлэхийг зорьжээ.

Түлхүүр үг: Монголын нууц товчоо, хэл, асуух сул үг

Хэл бол нийгмийн хөгжлийг дагалдан, тасрашгүй хөгждөг органик бүхэл цогц мөн. Хэлний хөгжлийн түүх бол уулаасаа эртний монгол хэл, дундад эртний монгол хэл, орчин цагийн монгол хэл мэтчлэн ил тод хувиартай байсангүй юм. Харин тус хэлийг эзэмшин хэрэглэж байгаа хүмүүс хэлийг ойлгох ба судалж шинжлэхэд дохомийг бодож, хэлний хөгжлийн түүхийг бэечээр шатлан хуваасан байдаг. Энэхүү биеч үйл ажиллагааны жолоодлого дор явагдсан шатлал хувиарлал нь хэлний хөгжлийн түүхийг тасдан салгаж байгаа биш харин хэлний олон шат үеийг хооронд нь харьцуулахаар дамжин, хэлний хөгжлийн дотоод жам хуулийг илрүүлэхэд суурь тавьсан явдал болно. Тус өгүүлэлд “Монголын нууц товчоо”-ны хэлэн дэх асуух сул үгийн хэрэглэгдсэн байдал, утга үйлдлийг орчин цагийн монгол хэлний сул үгтэй хооронд нь харьцуулахаар дамжин, зөрүүтэй талыг нь хураангуйлан гаргав.

Нэг. Асуух сул үг

“Монголын нууц товчоо” дахь асуух сул үг нь нэлээд онцлогтой хэрэглэгдэж байжээ. Манай бүртгэсэнээр асуух сул үг “Монголын нууц товчоо”-д ‘үү’ (Ү) нь 100 удаа илэрчээ. Өгүүлбэр дэх байрлал болон илтгэх угтын хувьд маш өвөрмөц бөгөөд бурилаантай, их төлөв доорх мэт хэдэн зүйлийн байдалтай.

(Нэг) Асуух төлөөний үргэлж асуух өгүүлбэрт үйл өгүүлэхүүний эцест байрлах

泰赤兀_惕 阿_中合_中迭兀因_中合失温 倒兀孙 牙丹 哈赤 客捏 阿不舌_中闌 赤荅_中忽讷? (§77).

(Тайчууд ах дүүгийн гашуун дуусан ядан ач хэнээ авран чадах уу?)

诃額_可額客_可兀_惕 帖延_帖 兀都_古儿_儿 兀者_古因_因 你敦_敦 雪泥_雪 莎那思_中忽因_因 赤勤_勤 客捏_客字_勒
合_中忽由_由? 客延_格舌_舌儿_儿 朵脱_古刺_刺 帖只_只額_額罷_罷. (§138)

¹ Тус өгүүлэл бол Улсын Нийгмийн Шинжлэх Ухааны суурь мөнгөний төсөл “Сураг занги шийдвэрлэлтэд зориулсан монгол хэлний тэмдэг нэрийн утгалбарын толийн цогцолц ба биелүүлэлт” (Зөвшөөрөгдсөн дугаар: 16ХҮҮ022)-ын шатач чанартай бүтээл болно. Өвөр Монголын Өөртөө Засах орны монгол үг хэл, үсэг бичгийн судалгааны сэдэв “Хамниган-Монгол аялгуу хийгээд дундад эртний монгол хэлний авианы харьцуулсан судлал” (Зөвшөөрсөн дугаар: MY-YB-2018006)-ын судалгааны шатач чанартай бүтээл болно.

(Өэлүн эх хөвгүүддээ одор үзэхийн нүдэн шөнө сонсохын чихэн хэнээ болгох уу?” хэмээн гэр дотор тэжээв.)

Энэ онцлогоороо орчин цагийн монгол хэлээс ялгагдаж буй. Орчин цагийн монгол хэлний асуух сул үг ‘уу, үү’ нь асуух төлөөний үгтэй өгүүлбэрт ер нь ордоггүй.

(Хоёр) Асуух төлөөний үггүй, асуух өгүүлбэрт байрлах

1. Жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэрийн дараа хэрэглэхдээ өгүүлбэрийн дунд буюу тэмдэг нэрийнх нь дараа, туслах үйл үгийнх нь өмнө ордог. Жишээ нь:
完_勒者 兀 客額周 阿_卜中忽 必? (§92)
(Олз уу хэмээж авах би?)
必答 额捏 阿讷 也客 兀格 突_舌儿 失_中罕 栎_舌骊刺周 幹_揚抽, 阿讷 中豁_舌儿 阿不
阿速 别_舌儿客都 兀 阿 主 兀? (§190)
(Бид энэ ану их үгд шахан морилж одож, ану хур авбаас бэрхт үү ажгуу?)
米纳 兀_舌魯_黑 突_舌儿 你客讷 兀 撒因 兀祿 脱_舌列古 阿主兀? (§255)
(Миний урагт нэгэн үү сайн үл төрөх ажгуу?)
2. Тэмдэг үйл үгийн (-qu/-kü) ба (-qun/-kün) дагаврын дараа байрлах. Жишээ нь:
那可_Γ 必 赤_Γ察_Γ吉_Γ迭_Γ抹_舌麟的_Γ阿_卜中忽 兀 不列_Γ? (§92)
(Нөхөр, би чамаас ангид эд морьдоо авах уу бөлгөө?)
那可徹_勒 兀格溫 哈_舌闌, 图_思中合你顏_中合_舌儿苔_黑撒_揚 哈_舌刺泥 抹可_舌里兀_勒迭坤
客額周 抹可_舌里兀_勒迭古讷兀_勒必答? (§149)
(Нөхцөл өгөх аран, тус ханаа гардагсад арныг мөргөлдүүлэн хэмээж мөргөлдүүлнэ
үү бид?)
札_勒中含失_黑壇 泰赤兀_揚 阿亦孙 阿_中忽讷? 额客, 幹帖儿 孜思! 客額毕. (§149)
(Залгамшигтан тайчууд айсун ахун уу? Эх үтэр бус уу хэмээв)
3. Үйл үгийн өнгөрсөн цагийн (-ba/-be) дагаврын дараа орно. Жишээ нь:
田迭 诃額仑兀真 鸣诂列_舌论: 帖迭 中忽儿班 哈_舌刺泥 兀_中合巴 兀 赤? ... 客延
(§55)
(Тэнд Өэлүн үжин өгүүлрүүн: Тэд гурван арныг ухав уу чи... хэмээн)
4. Зэрэгцэх нөхцөл үйл үгийн дараа орсон. Жишээ нь:
主_中合主 兀 格速 客額列埃 塔? (§179)
(Зугааж уу хэс хэмлэхэй та)
不_壳抽兀 阿梅? (§103)
(Бөхөж үү амуй?)
5. Ялгах төлөөний үгийн дараа орсон. Жишээ нь:
斡那_舌儿 你刊壇 不速禿 必答 ? (§105)
(Үнэр нэгтэн бусуд уу бид?)
忙_中豁勒 者 安苔_中合_舌儿壇 不速禿 ? (§108)
(Монгол за андгайтан бусуд уу?)
6. Биеийн төлөөний үгийн дараа үйл өгүүлэхүүний өмнө байрласан. Жишээ нь:
不亦_舌魯_黑 中合罕 额赤格因 赤讷 勺般 额堆 中忽_舌里牙周 阿_黑三 兀魯昔 赤讷 马
納 兀 篓迭兀_勒古 ? (§167)
(Буйраг хан эцэг чинь зовон өдий хурааж агсан улсыг чинь ман уу мэдүүлэх?)
7. Үгүйсгэх сул үгийн ‘ул, эс, бус’-ын дараа хэрэглэсэн. Жишээ нь:
把_舌里_黑苔阿速 纳马宜 额亦木宜 兀祿 兀 只阿_中忽 不列额 赤 ? (§145)
(Баригдваас намайг ийм үл үү заах бөлгөө чи?)
必 你多泥 赤马苔 额 薛 兀 鸣诂列额 ? (§104)
(Би нүдний чамд эс өгүүлэх?)

只舌儿中豁都阿舌儿 迭兀 不速 兀 赤 ? (§203)

(Зургадугаар дүү бус уу чи?)

Үгүйсгэх сул үг ‘бүс’ бол нэр үгийг үгүйсгэхэд хэрэглэгддэг бөгөөд үгүйсгэж байгаа үгийнхээ хойно байршдаг. ‘Үл’ бол голдуу үйл үгийг үгүйсгэдэг. Заримдаа тэмдэг нэрийг үгүйсгэхэд бас хэрэглэнэ. ‘Эс’ бол зөвхөн үйл үгийг үгүйсгэх үед хэрэглэнэ. “Монголын нууц товчоон” дахь асуух сул үг ‘үү, үү’-ийн жишээдийг шүүгээд үзвэл үгүйсгэх сул үг ‘үл, эс’ бүхий өгүүлбэрт асуух сул үг ‘үү, үү’ үйл өгүүлэхүүнийхээ өмнө нь байрлах үзэгдэл нэлээд түгээмэл оршиж байсан гэлтэй. Гэвч орчин цагийн монгол хэлд харин хэрэглэгдэхээ болжээ. Ерөнхийлөн хэлбэл, “Монголын нууц товчоо”-ны хэлэн дэх асуух сул үг ‘үү, үү’ нь утга хэрэглээний хувьд орчин цагийн монгол хэлнийхтэй адил тал байгаа боловч нэлээд зөрүүтгэй газар бас бий. Энэ нь доорх хоёр талаар илэрч байна. Нэгд, түүний илрэх байр нь орчин цагийн монгол хэлнийхтэй адил бус газар бий. “Монголын нууц товчоо”-ны хэлэн дэх асуух сул үг ‘үү, үү’ өгүүлбэрийн эцэст байрлахаас гадна, өгүүлбэрийн дунд ч байрладаг. Орчин цагийн монгол хэлэнд өгүүлбэрийн эцэст тохиолддог, өгүүлбэрийн дунд ер нь тохиолддоггүй. Хоёрт, асуух төлөөний үг бүхий асуух өгүүлбэрт хэрэглэгдсэн. Энэ онцлогоороо орчин цагийн монгол хэлээс ялгагдаж байна. Орчин цагийн монгол хэлний асуух сул үг ‘үү, үү’ нь асуух төлөөний үгтэй өгүүлбэрт ер нь тохиолддоггүй.

Хоёр. “Монголын нууц товчоо”-ны хэлэн дэх асуух сул үгэнд холбогдсон нэгэн асуудал

Орчин цагийн монгол хэлний зүйн номууд ‘үү, үү’, ‘бүй’ гэх хоёр сул үг бий гэж үздэг. “Монголын нууц товчоо”-ны хэлэнд мөн ‘үү, үү’, ‘бүй’ гэх асуух сул үг бий хэмээн зарим судлаачид үздэг. (Ө.Мандах, 1997:373). Гэтэл зарим судлаач **備**-ийг асуух сул үг гэж үзэггүй. Сэцэнбаатар “Монголын нууц товчооны асуух сул үг” (1994:49-54) гэх өгүүлэлдээ **備**-ийг дурдсангүй харин **備**-ийг л асуух сул үгээр тайлбарласан байна. Тана “Монголын нууц товчооны хэлний хийсвэр үгийн тухай” (1990:341) өгүүлэлдээ мөн **備**-ийг л асуух сул үгээр үзсэн байна. “Асуух сул үг ‘үү, үү, бүй’-ын тухай гүехэн ойлголт” (Одончимэг, 1997:71-75) гэх өгүүлэлдээ бас орчин цагийн монгол хэлний асуух сул үгийн байдлыг өгүүлэхийн хамт, “Монголын нууц товчоо”-ны хэлэн дэх ‘бүй’-ын хэрэглэлтийг задлаад ‘бүй’ бол асуух утгыг илтгэж чадахгүй, иймээс ‘бүй’ бол жинхэнэ асуух сул үг биш, харин туслах үйл үгэнд тооцогдоно гэж үзсэн байна.

Бид ‘Монголын нууц товчоон’ дахь ‘бүй’-ийг шүүгээд үзвэл, ‘бүй’, ‘備’ гэх хэлбэрээр нийт 117 удаа илэрч, хажуугийн орчуулга нь ‘備’ гэх үг болно. Мэдээж асуух сул үгэнд үгсийн сангийн бодит утга байхгүй. Гэтэл ‘бүй’-ын хажуугийн орчуулгаас үзвэл түүнд ‘байх, орших’-ыг заасан бодит утга илэрч байна. Жишээлбэл:

1. 中晃中豁塔歹 察舌刺中合 额不格讷 可温 蒙力_克 幣亦舌刺 備 客額速 (§68)
(Хонходдай Чирхай өвгөний хөвгүүн Мэнлиг ойр буй хэмээвээс)
2. 也速该把阿禿儿 鸣诂列舌论: 朵脫舌刺 米讷 卵危 備. 迭儿格迭 虛 備 ? 客 頓 周 (§68)
(Есүхэй баатар өгүүлрүүн: Дотор минь муу буй. Дэргэд хэн буй? хэмээж...)

Жишээ 1-д өгүүлэгчээс Хонходдай Чирхай өвгөний хөвгүүн Мэнлиг Есүхэй баатрын хажууд байна гэсэн утгыг энгийн маягаар хүүрнэж илтгэжээ. Энэ нь өгүүлэгч этгээдээс биеч талаас нотолж байх санаатай, орчин цагийн монгол хэлний ‘байна’-тай адил утгыг илтгэж байна. Жишээ 2 дахь ‘бүй’ бол асуух төлөөний үгтэй хамт асуух өгүүлбэрт оржээ. Гэвч асуух утгыг ‘бүй’ биш харин асуух төлөөний ‘хэн’ гэх үг тус санааг илтгэж байна. “Монголын нууц товчоон” дахь жишээнээс үзвэл ‘бүй’ гэх үг асуух төлөөний үг оролцохгүйгээр асуух өгүүлбэрт нэг ч удаа илэрсэнгүй. Иймээс нэг л адил ‘бүй’ гэх үгийг асуух өгүүлбэрт бол асуух утгыг илтгэж, хүүрнэх өгүүлбэрт бол баталсан нотолсон утгыг илтгэнэ гэхэд арай албадлагын чанартай шиг. Харин ‘бүй’-г үйл үгэнд багтаан, асуух өгүүлбэрт асуух утгыг

илтгэж байгаа нь ‘буй’ биш харин асуух төлөөний үг нь асуух утгыг илтгэж байна гэж үзвэл зүйтэй шиг санагдана.

“Монголын нууц товчоон”-д ‘буй и-а’ (備 者) гэх хэлбэр мөн асуух утгыг илтгэдэггүй. Нийт 59 удаа илэрч, хажуугийн орчуулгад нь (有, 也 者) гэх үг хадсан байна. Өгүүлбэрийн эцэст голдуу үйл үгтэй холbon хэрэглэдэг ‘и-а’(者) бол батласан утгыг илтгэдэг батлах сүл үг болно. Иймээс ‘буй и-а’(者)-ны өгүүлэгчийн биеч нотололыг улам нэг алхам баталсан санааг илтгэнэ. Жишээлбэл:

者勒蔑因 土撒 亦讷 幹樂 備者 (§211)

(Зэлмийн тус нь олон буй за)

中忽难，阔阔搠思，迭该，兀孙额不干 额迭 朵舌儿边 兀者克薛你颜 兀禄 你温，莎那速
撒你颜 兀禄 中合，赤中浑 不列额 额迭 朵舌儿边 備者. (§210)

(Гунан, Хөхөчүс, Дэгэй, Үсүн өвгөн эд дөрвөн үзсэнээ үл нуун, сонссоноо үл хавчихуун бүлгээ эд дөрөв буй за.)

Хурайнгуйлбал “Монголын нууц товчоо”-ны хэлэнд ‘буй’ нь голдуу биеэ даасан утгатай үйл үгээр хэрэглэгдэж, арай асуух сүл үг биш, гэвч зарим тохиолдолд утга нь хийсвэржээд асуух сүл үг болох хандаштай байсан төлөвтэй. Орчин цагийн монгол хэлэнд ‘буй’-гийн утга нь хийсвэржээд үйл үгийн хойно туслах үйл үгээр хэрэглэгдэх буюу асуух өгүүлбэрийн эцэст асуух сүл үгээр хэрэглэгдэж байна.

Номзүй

额尔登泰. 乌云达赉 蒙古秘史 校勘本. 内蒙古人民出版社年. 1980.

Баяр. 1980. Монголын нууц товчоон (дээд, доод). Өвөр монголын ардын хэвлэлийн хороор.

Мандах Ө. 1997. Эртний монгол хэл. Ляонингийн үндэсний хэвлэлийн хороо.

Шонхор. 1996. Эртний монгол хэлний судлал. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Монголын нууц товчоон. 1987. Ихмянгадай Ринчиний сэргээлт. Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо.

芬兰. G.J. 兰司铁 著. 周建奇 译 阿尔泰语言学导论. 内蒙古教育出版社. 2004.

(日) 小泽重男 著. 呼格吉乐图等 译 中世纪蒙古语诸形态研究. 内蒙古教育出版社. 2004.

陈乃雄. 保安语和蒙古语. 内蒙古人民出版社. 1987.

德力格尔玛. 波. 索德 蒙古语族语言概论. 中央民族大学出版社. 2006.

额尔登泰. 乌云达赉. 阿萨拉图. 蒙古秘史 词汇选释. 内蒙古人民出版社. 1980.

Хас-Эрдэнэ, Баянбаатар. 2006. Эртний монгол хэл. Өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо.

Сэцэнбаатар. 1992. Дундад зууны монгол хэлний хийсвэр үгс. Өвөр монголын их сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл.